

12

ИНТЕРНЕТИЙГ СУРГАЛТАНД АШИГЛАХ НЬ, ОНЛАЙН СУРГАЛТ

Б. Энхтуяа

Өнөөдөр компьютер, техник хэрэгсэл, мэдээллийн технологийн хөгжил асар хурдацтай хөгжиж байна. Сургалтанд ашиглах техник хэрэгсэлүүдийн нэр төрөл олон болж тэдгээрийг хэрэглэх хэрэглээ өндөрсөж байна. Одоогоос арван жилийн өмнө хувийн их дээд сургуулиуд байтугай улсын их сургуулиуд зөвхөн Monel, 286 гэх мэт төрлийн компьютер, техник хэрэгслүүд бүхий кабенетууд байсан бол одоо Монголын бараг бүх их дээд сургуулиуд өндөр хүчин чадалтай компьютер, техник хэрэгсэлүүдээр тоноглогдсон анги, кабенетуудтай болж тэдгээрийн ихэнхи нь интернэт болон дотоод сүлжээнд тодорхой хэмжээгээр холбогдсон байна. Үүнтэй уялдаад ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиудын сургалтын процесст компьютер техник хэрэгсэлийг ашиглах явдал нэмэгдэж байгаа боловч гадаадын их дээд сургуулиудтай харьцуулахад ашиглалт тун хангалтгүй байгаа билээ.

Монгол улсад хэдэн жилийн өмнө интернэт хомс байсан бол одоо интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд олноор гарч ирж, компани аж ахуйн нэгжүүд интернэтэд холбогдохын зэрэгцээ Соросын сан, Монголын нээлттэй нийгмийн хүрээлэнгээс санхүүжүүлэн хөдөө орон нутаг, аймгууд, ерөнхий боловсролын сургуулиудыг интернэтийн сүлжээнд холболоо. Зарим орон нутгууд интернэт төвтэй болж, Улаанбаатар хотод байгаа интернэт кафенуудын тоо эрс хурдтай өсөж байна. Энэ бүгдээс үзэхэд сургалтын техник хэрэгсэл, интернэтийг сургалтанд ашиглах явдлыг зөв оновчтой байдлаар нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах нь Монголын их дээд сургуулиудын хувьд хурцаар тавигдаж байна.

Сурах зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаандаа ашигладаг оюутны болон биет зүйлсийг сургалтын хэрэгсэл гэнэ. Харин суралцагсадад мэдлэг чадвар дадлыг үр дүнтэй олгох зорилгоор сургуулийн үйл явцад мэдээллийг дамжуулан боловсруулж буй болгохдоо аргазүйн хувьд хэрэглэж байгаа аппарат хэрэгсэлүүдийг сургалтын техник хэрэгсэл гэнэ.

Сургалтын техник хэрэгсэлийг сургалтанд ашигласнаар:

1. Суралцагсад гүн бат мэдлэг олгоно.
2. Суралцагчдыг бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулна
3. Багшийн сургалтыг удирдах процессийг хөнгөвчлөнө.
4. Хичээлтэй холбоотой нэмэлт мэдээллийг өгөх бололцоог нэмнэ.
5. Оюутан, сурагчдийг идэвхитэй, бие даасан, бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулна.

Сургалтын техник хэрэгсэлд:

1. Бодит зүйл буюу бодит юмс үзэгдлийн загвар

- Фото зураг
- Карт
- Схем
- Диафильм
- Кинофильм
- Дууны ба дүрсийн бичлэг
- Макет

2. Бичмэл зүйл

- Сурах бичиг
- Гарын авлага
- Бодлогын хураамж

3. Техник төхөөрөмжүүд

- Компьютер
- Кино
- Лингафоны кабинет
- Кодоскоп
- Телевиз гэх мэт

Оюутан сургалтын явцад мэдээллийг ойлгож хүлээж авах чадварыг нь сургалтын техник хэрэгсэл ашигласан байдлаар ангилан харуулбал дараах байдалтай байна.

Мэдээллийг ярьж илэрхийлснийг	2.8 сек-д
Өнгөт зураг, фото зургаар үзүүлснийг	09 сек-д
Теливиз, киноны байдлаар үзүүлснийг	0.7 сек-д
Бодит байдлаар үзүүлснийг	0.4 сек-д

Хүний үйл ажиллагаа хичнээн олон байна төчнөөн олон мэдрэмж байдаг. Сургалтын процессийг үр дүнтэй болгохын тулд суралцагсацийн мэдрэмжинд нөлөөлөх замаар сургалтыг явуулах хэрэгтэй гэж зарим эрдэмтэд үздэг.

Хүний мэдрэмжийг:

1. Өмнөх судалгаа шинжилгээ
2. Удамшил
3. Ардын арга гэх мэт зүйлийг харгалзан үзэж 2 хуваадаг.

Үүнд:

1. Амин мэдрэмж

- харааны мэдрэмж
- сонсголын мэдрэмж
- үнэр
- амт
- хүртэхүй

2. Сэтгэцийн мэдрэмж

- ухаарах мэдрэмж
- ес журмын мэдрэмж
- хэл ярианы мэдрэмж
- мэргэжлийн мэдрэмж

Сургалтын техник хэрэгсэлийг сургалтанд ашигласнаар харааны болон сонсголын мэдрэмжид илүүтэй нөлөөлөх бололцоотой. Хүн харааны мэдрэмжээр дамжуулан мэдээллийн 80 гаруй хувийг хүлээн авдаг. Харин 60 гаруй хувийг сонсголын мэдрэмжээр дамжуулан хүлээн авдаг.

Сургалтын техник хэрэгсэлийг иж бүрэн хэрэглэх зарчим нь:

1. Сургалтын техник хэрэгсэлээр үзүүлэх материал нь мэргэжлийн хувьд зайлшгүй байх
2. Үзүүлэх материалаа сургах зүйн талаас нь сайтар боловсруулсан
3. Сургалтын техник хэрэгсэлийн боломж нь үзүүлэн таниулах материалынхаа шинж байдалд зохицсон
4. Сургалтын техник хэрэгсэлийн боломж нь ашиглах нөхцөлтэйгээ уялдсан
5. Үзүүлж ярьж байгаа зүйл нь нэгдмэл
6. Үзүүлэх материалуудын хугацаа нь тохиромжтой болсон.

Сургалтын техник хэрэгсэлүүдийн дундаас сургалтын тоног төхөөрөмжүүдийг хэрхэн сургалтанд ашиглах талаар, тэдгээрийн давуу тал боломжуудыг тайлбарлая.

Компьютерийг сургалтанд ашиглах

Компьютерийн техник технологийн дэвшил асар хурдацтай хөгжиж байна. Хүн төрөлхтөний өмнө мэдээллийн цоо шинэ ертөнц нээгдэж байна. 30-аад жилийн өмнө нэг ч гар утас, нэг ч зөөврийн компьютер, интернэтийн сүлжээ байсангүй.

Электрон шууданг зөвхөн цэрэг дайны болон шинжлэх ухааны зориулалтаар ашигладаг байсан. IBM фирмийн персонал компьютер гарахад дараагийн жилүүдэд дэлхий дахины хөгжилд ямар нөлөө үзүүлэхийг хэн ч төсөөлж байсангүй. Харин өнөөдөр хүн бүр тоглоом тоглохоос эхлээд бичиг баримт бэлтгэх, хөгжим зохиох, өрхийн санхүүгийн тооцоо хийхдээ ч компьютер ашиглаж байгаа бөгөөд ихэнх компьютер интернэтэд холбогджээ. Сонин хэвлэл, сэтгүүлүүд реклам, зар суртчилгаа интернэтээр авч, бизнесийн бүхий л төрлийн гэрээ хэлэлцээр интернэтээр хийгдэж, бүхий л төрлийн онлайн (online) сургалтууд явагдаж байна. Өнөөдөр манай оронд ч гэсэн онлайн математикийн олимпиад, шатрын тэмцээн амжилттай болж өнгөрлөө.

Мэдээлэл нэгээс нөгөөд шилжиж мэдлэг болдог. Мэдлэгийг үйл ажилгааны хэлбэрт оруулснаар ахин мэдээлэл болдог. Шинжлэх ухаан техник, мэдээллийг технологи улам үсрэнгүй хөгжиж байгаа үед бүхий л чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байгаа их дээд сургуулиудын хувьд хичээлийн процессд компьютерийг ашиглан тэдгээрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна.

Дараах үндсэн 3 чиглэлээр компьютерийг сургалтанд ашиглах боломжтой.

1. **Техник хангамж** - компьютерийн үндсэн тоног төхөөрөмжүүд, диск төхөөрөмж, принтер, дотоод сүлжээ гэх мэт хэрэгслүүдийг сургалтанд ашигласнаар хичээлийн үр дүн дээшилнэ. Эдгээр нь багш оюутнуудын сургалтын буцах холбоог удирдахад ихээхэн нөлөөтэй.
2. **Программ хангамжууд**. Компьютерийг программ хангамжгүйгээр төсөөлөхийн аргагүй юм. Сургалтанд компьютерийн үндсэн программ хангамжууд болон мэргэжлийн салбар

чиглэлүүдтэй холбоотой программ хангамжуудыг ашигласнаар оюутанд хичээлээр олгосон мэдлэг чадварыг бататган гүн бат мэдлэг олох, өөрийн суралцах үйл ажиллагаанд өндөр түвшний программ хангамжуудыг ашиглан цаг хугацаа хэмнэх, шинэ зүйлүүдийг олж мэдэх, компьютер дээр боловсруулсан мэдээлэлд өөрийн суралцаж буй мэргэжил чиглэлийн дагуу үнэлэлт дүгнэлт гаргаж, бодлого боловсруулах чадвар эзэмшсэн. Ялангуяа хэлний сургалт дээр илүү үр дүнтэй байдаг. Гадаад хэлний хичээлүүдийн программ хангамжууд их олон төрөл байдаг бөгөөд тэдгээр пакет програмуудын тусламжтайгаар оюутан өөрөө өөрийнхөө мэдлэгийг шалгах, үнэлж дүгнэх, чадвар, дадал эзэмших бүрэн бололцоотой.

3. **Интернэт** - Өнөөдөр манай оронд интернэтийн үйлчилгээ нэвтэрч эхлээд төдийлөн удаагүй ч гэсэн интернэтийг хэрэглэгчдийн тоо түргэн хурдтайгаар өсөж байна. Оюутан, багш нар интернэтээс хэрэгтэй мэдээллээ авч ашиглахын зэрэгцээ, электрон шууданг ашиглан дэлхийн өнцөг булан бүрийн хүмүүстэй санал бодлоо харилцан солилцож байна. Их дээд сургуулиуд төдийгүй арван жилийн дунд сургуулиуд интернэтэд холбогдож сурагчид интернэтээс мэдээлэл авах, мэдээлэл солилцох бүрэн чадвартай болж байна. Мөн компьютерийн технологийн дэвшил асар хурдацтай хөгжиж байна. Үүнтэй холбогдоод оюутнуудын компьютер дээр ажиллах бололцоо сайжирч, оюутнуудын суралцах гэр орны нөхцөл бололцоо сайжирч байна.

Интернэт ашиглан ОНЛАЙН сургалтыг явуулах

Өргөн уудам нутагтай, хүн ам таруу суурьшдаг манай орны хувьд хүн амынхаа боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэхэд "ОНЛАЙН СУРГАЛТ" нь нэн тохиромжтой. Онлайн сургалт нь багшийн хяналтан доор танхимд хичээллэх бус Суралцагсадын бие даан суралцах бүтээлч үйл ажиллагаан дээр тулгуурлан вэб браузерийн тусламжтайгаар мэдлэгийг олж авах хөгжүүлэх сургалт юм.

Энэ төрлийн сургалтууд нь:

- Зааж буй хичээлийн сэдэвтэй холбогдсон нэмэлт материалаа интернэтээс олж авах, интернэтээс төрөл бүрийн программ хангамжуудыг татаж авч ашиглах,
- Интернэтээс ном, сэтгүүлүүдийг үнэгүй авч ашиглах,
- Интернэт ашиглан курсын ажил, гэрийн даалгаварыг и-мэйлээр явуулах, багш оюутны харилцаа холбоонд интернэтийг ашиглах нь илүү үр дүнтэй
- Хичээлтэй холбоотой өөрийн санал бодлыг багштайгаа солилцох, хичээл багш, оюутан гурвын эргэх холбоог хангаж өгч байна.
- Гадаадын их сургуулиудын вэб хуудсаар аялаж электрон номын сан, онлайн лекцүүдтэй танилцах, гадаадын их дээд сургуулийн эрдэмтдийн дипломын ажил, диссертац, оюутнуудын курсын ажил зэрэгтэй танилцах холбоо тогтоож хамтран ажиллах бололцоотой.

Интернэтийг ашиглаж байгаа үед алсын зайн сургалтыг удирдах багш нь дараах үүрэгтэй байна.

1. **Удирдагч, жолоодогч, дэмжигчийн үүрэг.** Суралцагчдынхаа хэрэгцээ, сонирхлыг үндэслэн сургалтын зорилго, зорилтын дагуу хэнийг юунд, яаж сургах, ямар мэдлэг чадвар, дадлага олгохоо оновчтой тодорхойлох. Сургалтын зохион байгуулалтын ямар арга хэлбэр илүү үр дүнтэй болох вэ? Суралцагчийн сонирхолыг яаж татах вэ? гэдгээ зөв сонгон, хичээл заах арга барилаа тооцох хэрэгтэй.
2. **Туслах, зөвлөгчийн үүрэг.** Багш суралцагчийн дотны туслагч, зөвлөгчийн үүрэг гүйцэтгэнэ. Радио хичээлээ сонсч, сургалтын материалаа ашиглахад тусална.
3. **Хянах үүрэг.** Суралцагчдын хэрэгцээ сонирхолд сургалт маань тохирч байна уу? үгүй юу? Идэвхи ямар байна вэ? Ямар бэрхшээл тулгарч байна вэ? Үр дүн гарч байна уу? гэдгийг ямагт ажиглаж, судлаж дүгнэлт гаргана.

4. **Үнэлэх дүгнэх үүрэг.** Суралцагчийн боловсролын төвшин, мэдлэгийн хүрээнд ахиц гарч байна уу?

Интернэтийг сургалтанд ашиглах явцад зарим суралцагч багшаасаа туслалцаа авах, буцаж холбоо тогтоох зэрэг асуудалд маш идэвхитэй ханддаг бол нөгөө хэсэг нь тийм байж чаддаггүйгээс гадна амьдралын нөхцөл нь боломж олгодоггүй тохиолдол олонтой байдгийг анхаарууштай. Энэ тохиолдолд тэдэнтэй холбоо тогтоох, тэднээс санаа бодлыг нь болон сургалтын талаар мэдээлэл авах өөр арга хэлбэрийг сүвэгчлэх хэрэгтэй.

Интернэтийг сургалтанд ашиглахын өмнө бүрдүүлэх нөхцөл:

- Оюутнууд интернэтийг ашиглах чадвартай, өөрт хэрэгтэй мэдээллийг интернэтээс олж авах чадварыг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай.
- Электрон шуудангийн хаягтай, и-мэйлээр захиа бичих, и-мэйлд файл хавсарч явуулах чадвартай.
- И-мэйл хаяг нээх чадвартай.
- Үсгийн фонд, хавсарч явуулах файлын онцлог, программыг урьдчилан тохирсон байна.
- Төрөл бүрийн программ хангамжууд интернэтээс татах чадвартай.
- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх шаардлагатай.

Багш, оюутны буцах холбоонд Е-мэйлийг ашиглах

Дараах хэлбэрээр и-мэйлийг багш оюутны буцах холбоонд ашиглаж болно.

1. Багш хичээлийн хуваариа оюутанд өгөх
2. Багш хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө өгөх
3. Багш зөвлөгөө өгөх цагаа мэдэгдэх
4. Эссе, реферат, дипломыг уншиж танилцах, эргэж хариу мэдэгдэх
5. Багш даалгавар өгөх, боломжтой, тест авах
6. Алсын зайн сургалттай холбоотой материалуудыг авах, хадгалах, хэвлэх боломжтой.
7. Зөвлөгөө авах.

Ач холбогдол:

1. Багш, оюутан хоёр цаг тохирох, хүлээхээс эхлээд дэмий үрэгддэг цагийг багасгана.
2. Курсын ажил, реферат зэрэгт оюутан суралцаж байх хугацаандаа ихээхэн хэмжээний цаас, хор, мөнгө зарцуулдагийг багасгана.
3. Мэдээллийн технологийг сургалт, судалгаандаа олшруулах чадвар нэмэгдэнэ.
4. Албаны ба хувийн бичгийн соёл дээшилнэ.
5. Алсын зайн сургалтанд илүү их үр дүнтэй.
6. Оюутнуудад санал бодлоо солилцоход илүү боломжтой багш нарын оюутантэй харьцах боломж ихсэнэ.
7. Оюутан дутуу ойлгосон юмаа мэдэж авах, багш оюутан юу нь дутуу ойлгож байна. юун дээр анхаарвал зохих эсэхийг болон өөрийн хичээл заалтанд дүгнэлт хийх, оюутанд хүрч ажиллах бололцоотой.
8. Оюутан гэрийн даалгаварыг хийхэд анги хамт олонтойгоо хамтран ажиллах, хамтран хичээлээ давтах, харилцан ярилцах боломж бүрдэнэ.

Бэрхшээлтэй зүйл:

- Багшид оюутантай ажиллах цаг нэмэгдэнэ.
- Янз бүрийн компьютер дээрээс файлууд ирдэгтэй холбоотойгоор компьютерийн вирусын асуудал гарна.
- Хичээл орохоос нэг хоногийн өмнө оюутанууд гэв гэнэт бүгд и-мэйл илрүүлэх явдал гарч байсан.

- Хичээлийн бус цагаар оюутан бүр суух компьютерийн хүрэлцээ хангамж муу г.м

Дүгнэлт

Бүхий л чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байгаа их дээд сургуулиудын хувьд оюутнуудад олгож байгаа мэдлэг, чадварыг улам дээшлүүлэх асуудал нарийн төвөгтэй болж байгаа ба шинжлэх ухаан мэдээллийн шинэ технологи улам үсрэнгүй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд улам хурцаар тавигдаж байна.

Сургалтын агуулга, багш нарын мэдлэг чадвар, материал, техник хангамж, ашиглаж байгаа сургалтын программ хэрэгсэл, заах аргазүй гэх мэт олон зүйлээс энэ асуудлын шийдэл хамаарч байгаа тул тал бүрээс нь асуудлыг нарийн боловсруулж цогцоор шийдвэрлэх хэрэгтэй юм.

Түүнчлэн энэ асуудлыг шийдэхэд сургуулиудын удирдлагын зүгээс анхаарч ажиллах, сургалтын техник хэрэгсэлийг иж бүрэн бүрэн төгс утгаар нь ашиглах нөхцөл бололцоог нь сайжруулах тал дээр ихээхэн зүйл хийх шаардлагатай байна. Сургалтыг зөвхөн самбар шохойтойгоор явуулах нь үеэ өнгөрөөсөн гэдгийг сургалт явуулж буй хүмүүс, сургуулийн удирдлагууд анхаарч дорвитой алхам хийх цаг мөч тулж ирлээ. Хий хоосон компьютер, сургалтын холбогдолтой видео кассетууд, CD-г нэмэх биш тэдгээрийн ашиглалтанд онцгой анхаарч хяналт тавьж тэдгээр нөөц бололцоог багш нар ашиглуулах тал дээр онцгой анхаарч, багш нарын сургалтын үйл ажиллагааг идэвхижүүлж өгөх асуудал өнөөдөр чухал боллоо.

Ашигласан материал

1. "Хүн мэдрэмжийн тухай онолын үндэс" Я.Хишигт 1999 он, УБ.
2. "Сургалтын техник хэрэгсэлүүд, эдгээрийг хэрэглэх аргазүй" Ц.Содов, Д.Отгонбаяр, 1987 он.
3. "Телевиз, компьютерийг сургалтанд хэрэглэх онцлог боломж" Ц.Содов, 1987 он.
4. "Шавь төвтэй сургалтын технологи" Боловсрол судлалын хүрээлэн, 1996. УБ.
5. "Сургалтын аргыг боловсронгуй болгох асуудалд" 1975 он.
6. "53 Interesting things to do in you lectures Bristol: Technical&Educational Service" 1988.
7. Cannon.R, 1988 Lecturing. HERDSA, Green Guide No 7. Kenkington. NSW, Higher Education Research and Development Society of Australia.
8. Curtin University of Technology «Teaching at University» Alex Radloft Eamon Murphy.
9. «Teaching Learning Methodlogies» Module 1. United Nations Development Programm, MON/95/101.
10. «Processes for group FACILITATORS» Christine Hogan, School of Management& Marketing, Curtin University of Technology. 1995.
11. "Багш та" Сурч амьдаръя төсөл, ЮНЕСКО 1998.